

НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ТҮГЖРЭЛИЙГ БУУРУУЛАХ, ГЭР ХОРООЛЛЫГ ОРОН СУУЦЖУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх” гэж, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлж, хүний аюулгүй байдлыг хангах” төрийн үүргийг тодорхойлсон.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 3.2.5-д “Хот, суурин газрын гэр хорооллыг иргэдийн оролцоотойгоор дахин төлөвлөх, төвлөрсөн, хэсэгчилсэн, бие даасан инженерийн дэд бүтцэд холбогдсон орон сууцны хороолол болгон хөгжүүлнэ” гэж, 3.2.13-т “Гэр хорооллын дундын болон захын бүсийг тэргүүн ээлжинд инженерийн дэд бүтэцтэй болгоход улс, орон нутгийн төсөв болон бусад хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг зориулах, иргэдийн хүсэл, санаачилгад үндэслэн дэд бүтэц бүхий газрыг төр, эсхүл хувийн хэвшлийн орон сууцаар шууд солих замаар дараагийн орон сууц баригдах талбайг бий болгоно” гэж, 9.3.27-д “Орон зайн оновчтой төлөвлөлт бүхий суурьшлын зөв тогтолцоотой, эрчимтэй хөгжиж байгаа дагуул хотуудтай олон улсад өрсөлдөгч метрополитан болж хөгжих зорилтын хүрээнд авто зогсоолын менежментийн боловсронгуй тогтолцоог бий болгох, Улаанбаатар хотын авто замын бүсчлэлийг тогтоож, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зохицуулах” гэж тус тус заасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 6.1-д “Улаанбаатар болон дагуул хотыг орон зайн оновчтой төлөвлөлт, ухаалаг шийдэл, амьдралын таатай орчин бүхий ногоон хот болгож хөгжүүлэх зорилтын хүрээнд Улаанбаатар хотын замын хөдөлгөөний нягтралыг сарниулж, ачааллыг тэнцвэржүүлсэн, тээврийн эрэлтэд нийцсэн авто замын сүлжээг бий болгож, түгжрэлийг бууруулна.” гэж заасан.

Мөн дээрх хөтөлбөрийн 2.5.3, 6.1.2, 6.1.3, 6.2.8-д хуримтлалын нэгдсэн сангаар дамжуулж, иргэн бүрийн боловсрол, эрүүл мэнд, тэтгэвэр, орон сууц, нийгмийн хамгааллын үйлчилгээг цогцоор нь шийдвэрлэх тогтолцоонд үе шаттайгаар шилжүүлэх, Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслүүдийг эрчимжүүлж, соёл, боловсрол, худалдаа үйлчилгээ, орон сууц, нийгмийн болон инженерийн дэд бүтцийн хангамж бүхий Баянхошуу, Сэлбэ, Дамбадаржаа, Дэнжийн 1000, Толгойт, Шархад, Дарь-Эх дэд төвүүдийг шинээр байгуулах, хотыг дахин хөгжүүлэх төслийн хүрээнд орон сууцны хангамжийг нэмэгдүүлж, гэр хорооллын газрыг шинэчлэн зохион байгуулж, ногоон орон сууц, шинэ суурьшлын бүсийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, инженерийн хангамжтай орон сууц болон хувийн сууцны хангамжийг нэмэгдүүлж, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэхээр заасан.

Улаанбаатар хотын суурьшлын нягтрал нь зах зээлийн эдийн засагт шилжсэнээр нийлэл рүү чиглэсэн хүн амын шилжих хөдөлгөөн 1990 оноос хойш эрчимтэй нэмэгдэж, 1990 онд 560.6 мянган хүн амтай байсан нийслэл Улаанбаатар

хот 2000 онд 747.1 мянга, 2010 онд 1112.3 мянга, 2023 онд 1691.7 мянган хүн амтай болж 3 дахин өсөж, 2045¹ он гэхэд 2 779 642 болж өсөх төлөвтэй байна.

2023 оны байдлаар 1.6 сая хүн буюу улсын нийт хүн амын тал хувь нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн 0.3 хувийг эзэлдэг нийслэл Улаанбаатар хотод суурьшин амьдарч, жилд дунджаар 40 гаран мянган иргэн шинээр бүртгэгдэж байна.

Хотын хүн амын өсөлт, хотжилт, түүнийг дагасан тээврийн хэрэгслийн тооноос шалтгаалан Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэл сүүлийн жилүүдэд үлэмж нэмэгдсээр байна. Манай улсад 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 1.2 сая орчим тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаагийн 56 хувь буюу 712,992 нь Улаанбаатар хотод бүртгэлтэй байна. Сүүлийн 10 жилд улсад бүртгэлтэй тээврийн хэрэгслийн тоо 107 хувиар буюу 2 дахин, үүнээс Улаанбаатар хотод бүртгэлтэй тээврийн хэрэгслийн тоо 93 хувиар хувь буюу 1.9 дахин нэмэгдсэн байна. Сүүлийн 3 жилийн байдлаар жилд дунджаар 47000 тээврийн хэрэгсэл нийслэл Улаанбаатар хотод бүртгэгдэж байна.

Улаанбаатар хотын гол гудамж, туслах гудамжны хөдөлгөөний ачааллын нөхцөл байдлаас үүдэн замын даац 2 дахин хэтэрсэн, тээврийн хэрэгслийн дундаж хурд 9км/цаг-13км/цаг болжээ.²

Япон улсын Жайка олон улсын байгууллагаас хийсэн судалгаагаар нийслэл Улаанбаатар хотын автомашины импорт энэ чигээрээ хурдацтай нэмэгдсээр байвал зам дээрх тээврийн хэрэгслийн дундаж хурд 2025 онд 8 км/ц, 2030 онд 5 км/ц, улмаар 2040 он гэхэд авто замын урсгал хэт түгжрэлд зогсох төлөвтэйг тооцоолоод байна.

Ийнхүү хотын хүн амын болон тээврийн хэрэгслийн өсөлт, хот төлөвлөлтийн уялдаа, сургууль цэцэрлэгийн хүртээмжгүй байдал, зах, худалдааны төвийн бөөгнөрөл, замын хөдөлгөөний соёл зэргээс үүдсэн авто замын хэт ачаалал бий болж иргэдийн эрүүл, аюулгүй амьдах эрх зөрчигдөхөд хүрч байна

Судалгаагаар Улаанбаатар хотын 2021 оны түгжрэлийн алдагдсан боломжийн өртөг 3.82 их наяд төгрөг буюу 1,245 сая ам доллар болохыг тогтоожээ. Энэ нь Улаанбаатар хотын ДНБ-ний 16 хувь, Монгол Улсын ДНБ-ний 9 хувьтай тэнцэхүйц хэмжээний дүн бөгөөд нийслэл хотын хүн амын тоонд харьцуулан үзвэл нэг хүнд ногдох өртөг 2 478 758 төгрөг байна.³

Замын хөдөлгөөний түгжрэл, саатлыг бууруулах зорилгоор 2020 онд Нийслэлийн Засаг даргын захирамжаар “Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоох журам”, “Тээврийн хэрэгслийн улсын дугаараар ялгаж замын хөдөлгөөнд оролцуулах цаг, нутаг дэвсгэрийн бүсчлэл”-ийг тогтоосон ч журмын хэрэгжилт хангалтгүй, өсөн нэмэгдэх импортын автомашины тоог замын нэвтрүүлэх чадвар хангаж чадахгүй байна. Судалгаагаар нийслэлийн дугаарын хязгаарын үйлчлэл 30%-тай байх бөгөөд хориглосон цагуудаар зорчдог тээврийн хэрэгсэл ажлын 5 хоногт дунджаар 57 мянга байна.⁴

¹ ҮСХ, Хүн амын 2015-2045 оны шинэчилсэн хэтийн тооц. Эм эм си жи, “Түгжрэлээс үүсэх нийгэм эдийн засаг, байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл, алдагдсан боломжийн өртөг тооцох”-оо, 2017 он

² Эм эм си жи, “Түгжрэлээс үүсэх нийгэм эдийн засаг, байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл, алдагдсан боломжийн өртөг тооцох”

³ Эм эм си жи, “Түгжрэлээс үүсэх нийгэм эдийн засаг, байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл, алдагдсан боломжийн өртөг тооцох”

⁴ Монголын дата клуб, Улаанбаатар хотын автомашины болон зорчилтын өгөгдлийн шинжилгээ, 2022

Авто замын түгжрэлийг бууруулах үндсэн онол (Антони Давнс)-оор авто замын сүлжээг нэмэгдүүлэх, өргөтгөх, эсвэл эгнээний тоог нэмэгдүүлэх арга хэмжээнүүд нь замын түгжрэлд үр ашигтай нөлөө үзүүлдэггүй гэж үздэг. Улаанбаатар хотын авто замын сүлжээний урт сүүлийн 10 жилийн хугацаанд⁵ 531 км-ээс 1213 км болж 43 хувиар нэмэгдсэн ч тус хугацаанд 1.9 дахин нэмэгдсэн 712,9 мянган нийслэл хотод бүртгэлтэй тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг авто замын нэвтрүүлэх чадвар хангаж чадахгүй байна.

Улс орнууд төлбөртэй бүс тогтоох, шатахууны борлуултад татвар ногдуулах, төлбөртэй зам барих зэргээр замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах олон шийдлийг хэрэгжүүлж байгаагаас төлбөртэй бүс тогтоох нь замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулахад өндөр нөлөө үзүүлж байна. Сингапур, Лондон, Стокхолм хотуудын туршлагаас харахад төлбөртэй бүс тогтоох замаар авто машинаар зорчих дадлыг өөрчилж, иргэдийн зорчилтийг илүү үр дүнтэй болгосноор түгжрэлийг 20-30 хувиар бууруулсан сайн туршлага байна. Түгжрэлийн төлбөрийн орлогоор нийтийн тээврийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, явган алхах, дугуй унах хэвшлийг түгээн дэлгэрүүлж замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулаад зогсохгүй хүн амын эрүүл мэндийг хамгаалахад үр дүнтэй зарцуулж байна.

Тээврийн хэрэгслийн тоог хязгаарлах, цаашид хэвийн хэмжээнд байлгахын тулд Улаанбаатар хотын тээврийн эрэлтийн менежмент, ялангуяа түгжрэлийн төлбөрийн тогтолцоог бий болгох нь автомашины хэрэглээг бууруулах, нийтийн тээвэр, моторт бус тээврийн хэрэгслийг идэвхжүүлэх, түгжрэлийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэнэ гэж үзэж байна.

Манай улсын хувьд нийслэлийн хэмжээнд 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 412.5 мянган өрх амьдарч байгаагаас 51.4 хувь буюу 212 мянган өрх нь орон сууцанд, үлдсэн 48.6 хувь буюу 200 мянган өрх нь гэр хороололд амьдарч байна. Нийслэлийн хүн амын тал хувь нь гэр хороолол буюу инженерийн дэд бүтцийн хангамжгүй, агаар, хөрсний бохирдолтой нөхцөлд амьдарч байгаа нь тулгамдаж буй олон асуудлын эх үүсвэр болж байна.

Улаанбаатар хотын хэмжээнд агаар, хөрсний бохирдлын 80 хувь нь гэр хороололоос үүдэлтэй гэсэн судалгаа гарсан. Тодруулбал, гэр хороололд 163,742 яндан байгаа нь агаарын бохирдлын 31 хувийг үүсгэж байна.

Хөрсийг бохирдуулж буй үндсэн хүчин зүйлсийн нэг нь гэр хорооллын нүхэн жорлон болоод байна. Гэр хорооллын нийт өрхийн 92.3 хувь нь буюу хөрсийг бохирдуулагч, эрүүл ахуйн шаардлага хангаагүй 144 992 нүхэн жорлонтой байна.

Агаар, хөрс, орчны бохирдлын асуудлуудыг шийдвэрлэх, гэр хорооллын иргэдийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулах үндсэн шийдэл, хамгийн оновчтой гарц нь гэр хорооллыг инженерийн дэд бүтцээр хангах, дахин төлөвлөн барилгажуулах юм. Гэр хорооллын замбараагүй тэлэлтийг хязгаарлах, нягтаршлыг зохицуулах зорилгоор цөөнгүй бодлого, төлөвлөгөөг боловсруулж батлуулсан ч хэрэгжилт хангалтгүй байна.

Тухайлбал, Эм Эм Си Жи судалгааны байгууллагаас 2020 онд хийсэн “Нийслэлийн орон сууцны эрэлт, нийлүүлэлтийн судалгааны тайлан”-нд дурдснаар Улаанбаатар хотод нийт айл өрхийн 64% нь буюу 290 232 өрхөд ирэх 3 жилд буюу 2022-2024 онд инженерийн дэд бүтэц бүхий орон сууцтай болох хэрэгцээ байгаа

⁵ Нийслэлийн статистикийн газрын цахим мэдээллийн сан /Сайжруулсан авто замын урт, км/ <http://ubstat.mn/StatTable=50>

бол 21% нь 81 895 өрхөд инженерийн дэд бүтэц бүхий орон сууцтай болох хэрэгцээ байхгүй бөгөөд одоогийн амьдарч буй гэр хорооллын сууцны нөхцөлөө сайжруулах хүсэлтэй байна. Мөн 12% буюу 47 746 өрхөд ирэх 3 жилд түрээсийн орон сууцанд амьдрах хэрэгцээ шаардлага байгаа талаар дурджээ.

“Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц төсөл”-ийн багийн 2022 оны 09 дүгээр сард хийсэн судалгаагаар Улаанбаатар хотын Баянхошуу, Толгойт, Сэлбэ, Дамбадаржаа болон Шархад дэд төвүүдийн ойролцоох судалгаанд хамрагдсан гэр хорооллын нийт иргэдийн 70% нь газрыг дахин төлөвлөж барилгажуулах төсөлд орох сонирхолтой байна.

Тухайлбал, Сэлбэ дэд төвийн хамрагдсан нийт талбарын 69% нь газрыг дахин төлөвлөж барилгажуулах төсөлд орох сонирхол илэрхийлсэн бол эдгээр иргэдийн 78% нь амьдарч буй газраа орон сууцаар солих хүсэлтэйгээ илэрхийлсэн байна.

Харин Баянхошуу дэд төвийн талбарт хамрагдсан нийт талбарын 71% нь газрыг дахин төлөвлөж барилгажуулах төсөлд орох сонирхол илэрхийлсэн бөгөөд эдгээр иргэдийн 73% нь амьдарч буй газраа орон сууцаар солих хүсэлтэйгээ илэрхийлсэн байна.

Сэлбэ, Баянхошуу дэд төвүүдийг орон сууцжуулах төсөл хэрэгжүүлэх ажлын хүрээнд газар эзэмшигч, өмчлөгч иргэдийн дунд 2023 оны 09 дүгээр сард явуулсан санал асуулгаар Баянхошуу дэд төвд хамрагдах 1813 нэгж талбар (162 га)-аас 85.3% нь, Сэлбэ дэд төвд хамрагдах 2003 нэгж талбар (158 га)-аас 82.8% нь Нийслэлийн орон сууцны корпораци ХК-иар хэрэгжүүлэхийг тус тус дэмжсэн байна.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах нийгэм болон хууль зүйн баталгааг бүрдүүлэх, Монгол Улсын Их Хурлаас баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төслөөр нийтийн тээврийн төрөл хүртээмж, авто зогсоолын ашиглалтыг сайжруулах, замын хөдөлгөөний төлбөртэй бүсийг тогтоох замаар замын хөдөлгөөний эрчмийг нэмэгдүүлэх, төвлөрөл сааруулах, гэр хорооллыг орон сууцжуулах, замын хөдөлгөөний түгжрэл, агаар, хөрсний зэрэг орчны бохирдлоос үүсэх нийгэм, эдийн засгийн нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахаар боловсруулсан.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл нь 6 бүлэг, 27 зүйлтэй бөгөөд хуулийн төсөлд дараах зарчмын шинжтэй зохицуулалтыг тусгасан.

Нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, хууль тогтоомж, үйлчлэх хүрээ, нэр томъёоны тодорхойлолт, нийслэл хотын замын хөдөлгөөний түгжрэлийн нөлөөллийг бууруулах үйл ажиллагаанд баримтлах зарчмыг тусгасан.

“Замын хөдөлгөөний түгжрэл”, “замын хөдөлгөөний төлбөртэй бүс”, “нийгмийн зайлшгүй хэрэгцээ” зэрэг нэр томъёог тодорхойлж, тус хуулийн үйлчлэх хүрээг Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын нутаг дэвсгэр байхаар хязгаарлав.

Нийслэл хотын замын хөдөлгөөний түгжрэлийн нөлөөллийг бууруулах үйл ажиллагаанд нийтийн эрх ашгийг эрхэмлэж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангасан байх, иргэдийн оролцоог хангасан байх, шуурхай, тасралтгүй, ил тод байх, төрийн байгууллагын үйл ажиллагааны уялдааг хангасан байх зэрэг зарчмыг баримтлахаар тусгав.

Хоёрдугаар бүлэгт замын хөдөлгөөний төлбөртэй бүсийн төлбөр, түүнийг тогтоох, мөрдөх журам, авто зогсоолын талаар тусгасан.

Нийслэлийн Засаг дарга замын хөдөлгөөний төлбөртэй бүс, түүний хилийн зааг, цагийн хязгаарыг тогтоож, бүсэд мөрдөх журмыг батлахаар зохицуулсан.

Тус хуулийн төсөлд авто зогсоолын төрөл, тэдгээрт тавигдах нийтлэг шаардлагыг хотын стандартаар тогтоох, авто зогсоолын менежментийг сайжруулах, нэгдсэн систем бий болгох асуудлыг нийслэлийн Засаг дарга хариуцахаар тусгасан.

Төлбөртэй бүсэд тогтоох төлбөрийг бүсэд нэвтрэх тоогоор 0-ээс хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 5 хүртэл хувьтай тэнцэх мөнгөн дүнтэй байхаар хуулиар тогтоож, төлбөрийн хэмжээг энэ хязгаарт багтаан нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоохоор тусгасан.

Төлбөртэй бүсийн төлбөрөөс тус бүсэд оршин суугч иргэний тээврийн хэрэгслийг 90 хувиар, зөвшөөрөлтэй такси үйлчилгээг 50 хувиар хөнгөлөхөөр тусган такси үйлчилгээ эрхлэгчид зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрдүүлэхийг зорьсон.

Гуравдугаар бүлэгт нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх, такси үйлчилгээний хяналт, зохицуулалт, нийслэл хотод олгох тээврийн хэрэгслийн бүртгэл, дугаарын хязгаар, нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн талаар зохицуулсан.

Хуулийн төсөлд Нийслэл хот нь нийтийн тээврийг хөгжүүлэх урт, дунд хугацааны төлөвлөлт, багтаамж ихтэй, олон төрөлт нийтийн тээвэр, түүнийг дэмжсэн дэд бүтэцтэй байхаар тусгалаа.

Замын хөдөлгөөний төлбөртэй бүсийн төлбөрийг нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх санд төвлөрүүлж, сангийн хөрөнгийг автобусны чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, шинэ төрлийн багтаамж ихтэй нийтийн тээврийн үйлчилгээг нэвтрүүлэх зэрэг нийслэлийн нийтийн тээврийг цогцоор хөгжүүлэх арга хэмжээнд зарцуулахаар тусгасан.

Такси үйлчилгээг хуульд заасан нөхцөл, аюулгүй байдлын шаардлагыг хангасан этгээд тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх, түүнд хяналт тавихаар зохицууллаа. Нийслэлийн авто замын даацыг харгалзан нийслэл хотод олгох тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарт хязгаарлалт тогтоохоор мөн тусгав.

Дөрөвдүгээр бүлэгт нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх үндэслэл, гэр хорооллыг орон сууцжуулах байршил, төрөөс үзүүлэх дэмжлэг, санхүүжилт, хэрэгжүүлэх байгууллагын чиг үүргийг тусгасан.

Хуулийн төсөлд нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд төвлөрлийг сааруулах, гэр хорооллыг орон сууцжуулах зорилгоор нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн нийслэлийн газар чөлөөлөх үндэслэлийг нарийвчлан тодорхойлж, газар чөлөөлөлтийн үйл ажиллагааны зарчим, нөхөх олговрын хэлбэрийг зохицуулсан. Газар чөлөөлөх үйл ажиллагаа, газар чөлөөлөлтийн санхүүжилт, нөлөөлөлд өртөж байгаа иргэн, хуулийн этгээдтэй байгуулах гэрээний загвар, маргааныг шийдвэрлэх зэрэг асуудлыг Засгийн газрын баталсан журмаар зохицуулахаар тусгасан.

Иргэдийн оролцоог ханган газар албадан чөлөөлөх шийдвэрийг гаргахад тухайн төсөл, арга хэмжээний нөлөөлөлд өртөж байгаа газар өмчлөгч, газар эзэмших эрхтэй этгээд, улсын бүртэлд бүртгэлтэй үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч иргэн, хуулийн этгээдийн 65-аас доошгүй хувийн дэмжлэгийг авсан байхыг хуулийн төсөлд шаардсан.

Хуулийн төсөлд хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан байршилд заасан гэр хорооллыг нэн түрүүнд орон сууцжуулах, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлэх, тус үйл ажиллагааг нийслэлийн өмчит гэр хорооллыг орон сууцжуулах байгууллага хэрэгжүүлэхээр тус тус тусгасан.

Тавдугаар бүлэгт замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах талаар төрийн байгууллагын чиг үүрэг, оролцогчийн эрх, үүргийн талаар тусгав.

Хуулийн төсөлд замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах талаар Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргын чиг үүргийг тусгав.

Замын хөдөлгөөний түгжрэлийн нөхцөл байдлыг бүртгэх, боловсруулах, хяналт тавих, судалгаа хийх, мэдээллээр хангах, бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх чиг үүргийг нийслэлийн замын хөдөлгөөний удирдлага, зохион байгуулалтын асуудал хариуцсан байгууллагад хариуцуулахаар тусгасан нь замын хөдөлгөөний түгжрэлийн нөхцөл байдлыг бодитой мэдээлэх дэд бүтэц, хүний нөөцийг чадавхжуулах алхам болно гэж үзсэн.

Мөн иргэн, хуулийн этгээд замын хөдөлгөөний түгжрэлийн нөлөөллийг бууруулах эдлэх эрх, хүлээх үүргийн талаар энэ бүлэгт тусгасан.

Зургадугаар бүлэгт энэ хуулийг зөрчигчид хүлээлгэх хариуцлага, шилжилтийн үеийн зохицуулалт, хууль хүчин төгөлдөр болох хугацааг тусгасан.

Хууль батлагдсанаар хүлээгдэж буй үр дүн:

-соёл, боловсрол, спорт, худалдаа үйлчилгээ, орон сууц, нийгмийн болон инженерийн дэд бүтцийн хангамж бүхий дэд төвүүд шинээр бий болно;

-нийслэл хотын агаар, хөрс, орчны бохирдлын голомт болж байгаа гэр хорооллын бүс болох Сэлбэ, Баянхошуу дэд төвийг орон сууцжлуулах төслийг тэргүүн ээлжинд эхлүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлнэ;

- хүн амын орлогод нийцсэн, ногоон хөгжлийн загварт тохирсон орон сууц нийлүүлэлтийг хувийн хэвшлийн оролцоотойгоор нэмэгдүүлж, 19,500 орон сууц шинээр баригдаж, 68,250 хүн ая тухтай амьдрах орчин нөхцөл бүрдэнэ;

-зайлшгүй орон байраар хангагдах шаардлагатай зорилтот бүлгийн иргэдийг түр орон сууцаар хангадаг тогтолцоог нэвтрүүлнэ;

-Сэлбэ, Баянхошуу дэд төвүүдэд суурилсан 25,295 ажлын байр шинээр бий болж, дотоодын нийт бүтээгдэхүүн 2.5 их наяд төгрөгөөр нэмэгдэнэ;

-Сэлбэ, Баянхошуу дэд төвүүд бий болсноор агаарын бохирдол 22 хувиар, авто замын түгжрэл 36.3 хувиар буурах урьдчилсан тооцоололтой байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан дараах хууль тогтоомжид холбогдох өөрчлөлтийг оруулах төслийг боловсруулсан. Тухайлбал:

Монгол Улсын автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар нь иргэн, хуулийн этгээд автотээврийн хэрэгслийг эзэмшсэний төлөө төрөөс авч буй татвар тул цахилгаан тэжээлт автомашиныг эзэмшигч ч үүнд хамаарах нь зүйтэй гэж үзсэн. Иймд цахилгаан тэжээлт автомашины жилийн албан татварыг 2001 см³ хүртэлх моторын багтаамж бүхий суудлын автомашинаас авах татвартай адил тогтоохоор тусгав.

Нийслэл Улаанбаатар хотод бүртгэлтэй суудлын автомашины татварын дээд хязгаарыг 2 дахин нэмэгдүүлж тооцсон.

Монгол Улсын автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар хуульд заасан хязгаарт татварыг багтаан албан татвар төлөгчийн автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн бүртгэлтэй аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоох зохицуулалттай.

Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Автотээврийн хэрэгслийн хэрэглээг татварын бодлогоор хязгаарлах, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тэмцэх олон улсын гэрээ, конвенцийн дагуу Монгол Улс нь нүүрсхүчлийн хийн хэрэглээг хязгаарлах бодлогыг дэмжих, бий болгох шаардлагатай. Энэ хүрээнд нүүрсхүчлийн хийн хэрэглээнд шууд ногдуулдаг татвар бол агаарын бохирдлын төлбөр бөгөөд энэхүү төлбөрийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлэхээр хуулийн төсөлд тусгасан.

Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Монгол Улсын хүн амын 50 хувь, улсад бүртгэлтэй нийт тээврийн хэрэгслийн 56 хувь нь нийслэл Улаанбаатар хотод бүртгэлтэй байгаа бөгөөд тээврийн хэрэгслийн өсөлтийг тогтоон барих, замын даац хэтрэлтийг хэвийн хэмжээнд байлгах, замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах зорилгоор тээврийн хэрэгслийн дугаар олголтыг нийслэл хотод хэрэгжүүлдэг байхаар хуулийн төсөлд тусгасан.

Цагдаагийн байгууллагын гэмт хэргийн мэдээллийн санд 2018-2023 оны 9 сар хүртэл бүртгэгдсэн такси үйлчилгээтэй холбоотой гэмт хэргийн судалгаанаас үзэхэд нийт 3119 гэмт хэрэг бүртгэгдсэнээс нийслэлд дийлэнх буюу 2940 гэмт хэрэг бүртгэлтэй байна. Үүнээс 2636 гэмт хэрэгт таксины жолооч холбогдсон байна. Тодруулбал, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг /133/, хүчиндэх /60/, хулгайлах /433/, дээрэмдэх /223/, залилах /114/, алдаатай гүйлгээ, андуурсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө завших гэмт хэрэг/1698/-ийг жолооч үйлдсэн байна. Харин таксины жолооч өөрөө хохирсон нийт 336 гэмт хэргийн 304 гэмт хэрэг нийслэлд бүртгэгдсэн байна.

Нийтийн тээврийн болон такси үйлчилгээ эрхлэхэд тусгай зөвшөөрлийг олгодог байхаар зохицуулж, тодорхой нөхцөл, шаардлагуудыг тусгасан. Харин таксинаас бусад нийтийн тээврийн үйлчилгээний төлбөрийн хувь хэмжээг тогтоох асуудлыг зохицуулж, нийтийн тээврийн үйлчилгээний төлбөрийг орон нутгийн төрийн санд төвлөрүүлж, олон нийтийн хяналт тавих эрх зүйн орчныг бүрдүүлэхийг зорьсон.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Замын хөдөлгөөний төлбөртэй бүсийн бүртгэл, мэдээллийн санг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн нэг хэсэг байхаар тусгав.

Иргэн, хуулийн этгээд торгох шийтгэл, замын хөдөлгөөний төлбөртэй бүс болон авто зам, замын байгууламж ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг хугацаанд нь төлөөгүй, техникийн хяналтын үзлэг, оношилгоонд ороогүй тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцуулахыг хориглохоор тусгасан.

Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулиар гэр хорооллыг орон сууцжуулах асуудал тусгагдсантай холбогдуулан Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд зохицуулалтыг нийцүүлэх зорилгоор Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулиар тусгайлан зохицуулснаас бусад харилцааг Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулиар зохицуулахаар тусгав.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Хуулийн төслөөр дагуул хот, эдийн засгийн тусгай бүсийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох замаар нийслэл хотын төвлөрлийг сааруулах

Засгийн газрын бодлогыг бодитой хэрэгжүүлэх боломж бүрдүүлэхээр зорьсон. Тодруулбал, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нийслэл хотын эдийн засгийн тусгай бүсийг зөвхөн дагуул хотод байгуулахаар хуульчилсан нь дагуул хотыг байгуулах, түүний бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалттай холбоотойгоор цаг хугацаа их зарцуулах зэргээр эдийн засгийн тусгай бүс байгуулах боломжийг хязгаарлаж байгаа тул тусгай бүсийг нийслэлийн нутаг дэвсгэр, дагуул хот болон бусад орон нутагт тухайн засаг захиргааны нэгжтэй тохиролцсоны үндсэн дээр Засгийн газрын шийдвэрээр байгуулахаар тусгав.

Мөн нийслэл хотын дүрмийг зохицуулалтыг тодруулж, ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн, дуу чимээний бохирдол, хүүхдийн тоглоомын талбайн ашиглалт, хамгаалалт зэрэг зохицуулалт шаардлагатай, хотод тулгамдаж байгаа асуудлыг тухайлан нийслэл хотын дүрмээр зохицуулахаар тусгасан.

Монгол Улсын хэмжээнд бүртгэлтэй ачааны авто машины тоо 2023 оны эхний хагас жилийн байдлаар 202111 байгаа бөгөөд нийслэлд бүртгэлтэй ачааны авто машины тоо 90184 байгаа нь нийт автомашины 44.62 хувийг эзэлж байна. Нийслэлд бүртгэлтэй 90184 ачааны автомашинаас 19761 ачааны машин буюу 21% нь зөвшөөрөл авч, ачаа тээвэрлэж замын хөдөлгөөнд оролцож байна.

Нийслэл хотын замын хөдөлгөөнд ачааны автомашиныг цагийн хязгаарлалттай оролцуулах нь гудамж замын хөдөлгөөнийг зохицуулах томоохон хөшүүрэг болсоор ирсэн. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор батлагдсан “Нийслэлийн гудамж замын хөдөлгөөнд ачааны автомашиныг цагийн хязгаарлалттайгаар оролцуулах, түр зөвшөөрөл олгох журам” нь хуулиар тусгайлан эрх олгосон зохицуулалтгүй байсан.

Иймд харьяалах нутаг дэвсгэрийн замын хөдөлгөөнд ачааны, түгээлт, хүргэлтийн үйлчилгээний автомашиныг хязгаарлалттайгаар оролцуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгохоор хуулийн төсөлд тусгасан.

Нийслэл хотын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн Нийслэл хотын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар “автомашин угаалгын газар” болон нийтийн тээврээс бусад автотээврийн хэрэгслийн ашиглалттай холбоотой “авто үйлчилгээ үзүүлэгч”-ийн үйлчилгээнд нийслэл хотын албан татвар ногдуулахаар тусгасан. Гэвч Нийслэл хотын албан татвараас чөлөөлөх асуудлыг зохицуулсан 10 дугаар зүйлд холбогдох өөрчлөлтийг оруулаагүйгээс дээрх хоёр үйлчилгээ нь уг албан татвараас чөлөөлөгдөж татвар ногдуулж, хураах хуулийн үндэслэлгүй байсан. Иймд хуулийн дээрх заалт хоорондын зөрчилдөөнийг арилгах зорилгоор нийслэл хотын албан татвараас чөлөөлөгдөхөд хамаарахгүй үйлчилгээнд дээрх хоёр үйлчилгээг тусгахаар төслийг боловсруулав.

Хуульд өөрчлөлт орсноор нийслэл, дүүргийн татварын албанд бүртгэлтэй авто угаалгын үйлчилгээ эрхлэгч 167 татвар төлөгчийн 41.8 сая төгрөг, авто үйлчилгээ үзүүлэгч 457 татвар төлөгчийн 180.2 сая төгрөг буюу нийт 624 татвар төлөгчийн 222.0 сая төгрөгийг нийслэлийн төсөвт төвлөрүүлэх тооцоолол гарч байна.

Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Хуулийн төслөөр барилгажилт, нутаг дэвсгэрийн бүсчлэлийн ашиглалтын хязгаарлалтын норм зөрчигдсөн барилга байгууламжийн газрыг чөлөөлөх, орц, гарц гаргах, барилга байгууламж, зам, замын байгууламжийг шилжүүлэх, албадан буулгахтай холбоотой зардлыг буруутай этгээдээр гаргуулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ. Мөн нийт газар нутгийн 20-оос доошгүй хувь нь цэцэрлэг, ногоон байгууламж, 20-оос доошгүй хувь нь авто зогсоол, нийтийн амралт зугаалга, биеийн тамирын зориулалтын талбай байхаар төсөлд тусгасан. Ингэснээр эдэлбэр газрын 30 хувьд ногоон байгууламж, хүүхдийн тоглоомын талбайг хамтад багтаан төлөвлөж, түүний ихэнх хэсэгт авто зам, зогсоол төлөвлөж, амрах талбай, хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламж зэргийг маш бага хэмжээнд төлөвлөн байгуулж байгаа одоогийн нөхцөл өөрчлөгдөх болно.

Дээрх асуудалтай холбоотой гомдол санал жил ирэх тусам өсөж барилгатай холбоотой асуудлаар иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын 30-40%-ийг орон зайн төлөвлөлт, ногоон байгууламж, хүүхдийн тоглоом, авто зогсоолтой холбоотой гомдол эзэлж байна. Мөн 2020-2022 онд хийгдсэн тоглоомын талбайн судалгаагаар хорооллын доторх хүүхдийн тоглоомын талбай нь авто машины хөдөлгөөнөөс тусгаарлагдаагүй, олон хүүхдэд хүртээмжгүй, аюулгүй байдал алдагдаж байгаа нь хүүхдийн эрхийг зөрчиж байна.

Барилга бүрийн орчинд хангалттай хэмжээний ногоон байгууламжийг төлөвлөн байгуулсанаар орчны дуу чимээ, тоос, тоосонцорын бууруулах ач холбогдолтой. Түүнээс гадна хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, дахин боловсруулах, хог тээврийн менежментийг сайжруулах зорилтын хүрээнд орон сууцны бүсээс ялгарч буй ахуйн хог хаягдлыг эх үүсвэрээс нь ангилсан байдлаар ачиж тээвэрлэх шаардлагатай.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл (2005)

Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд хог хаягдлын үйлчилгээний чиглэлээр мэргэшсэн нийт 33 аж ахуйн нэгж, байгууллага ажилладаг. Үүнээс төсөвт байгууллага 11, хувийн хэвшил 22 байгууллага ажиллаж байна. Хот нийтийн аж ахуйн салбар дундаа хог тээвэрлэлт, зам талбайн цэвэрлэгээний ажил нь тогтмол тасралтгүй хийгддэг хотын урсгал үндсэн гол ажил бөгөөд урсгал ажлыг тасалдуулах нь ажлын бүтээмж, чанар харилцан адилгүй, тогтворгүй болж, гудамж зам талбай бохирдож, халтиргаа гулгаа үүсэх зэрэг нөхцөл байдал төсөвт жилийн эхний улиралд буюу 1-3 дугаар сард үүсдэг.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд /2005/ нийслэл хотын хот тохижилт, авто зам, халаалт, цэвэр, бохир усны шугам, үерийн далан сувгийн засвар, арчилгаа, хог хаягдалтай холбоотой ажил, үйлчилгээ, нийслэл хотод шаардлагатай машин техник, тоног төхөөрөмж, бараа, материалыг санхүүгийн түрээс /лизинг/-ээр худалдан авах болон нийслэл хотын аж ахуйн үйл ажиллагааг объект, талбайгаар нь ашиглалт засвар үйлчилгээг хариуцсан этгээд гэрээт хугацаанд нэмэлт шаардлагатай ажил үйлчилгээг гэрээ шууд байгуулах аргаар худалдан авалтыг зохион байгуулахаар тусгалаа. Ингэснээр нийслэлийн цахилгаан, дулаан, усаар тасрахгүй хэвийн байх, үер ус, бохирдол, хог хаягдал, ногоон байгууламж зэрэг хотын аж ахуйн үйл

ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх тусгай чиг үүргийн байгууллагууд гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх хотын аж ахуйн үйл ажиллагаа хэвийн тасралтгүй үргэлжлэх, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах амьдралын чанар нэмэгдэхэд оршино.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Хуулийн төслөөр орон нутгийн, хот доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээвэр, такси үйлчилгээг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх бөгөөд уг зөвшөөрлийг аймаг, нийслэлийн Засаг дарга олгохоор тусгасан.

Энэ хуулийн нэмэлтийг оруулснаар нийтийн зорчигч тээврийн болон такси үйлчилгээний хяналт, хариуцлагын тогтолцоо сайжирна гэж үзэж байна.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээг Зохицуулах зөвлөлөөс олгодог болон цахилгаан, дулаан түгээх, эрчим хүч, хийгээр хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд, аймаг, нийслэлийн Засаг даргатай гурвалсан гэрээ байгуулан ажиллахаар тусгасан.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулсантай холбогдуулан Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулсан болно.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Орон сууцны тухай хуулийн 15.1, 15.3-т заасныг зөрчиж нийтийн зориулалттай орон сууцны зориулалтыг өөрчилсөн бол холбогдох өөрчлөлтийг эрхийн улсын бүртгэлд бүртгэхийг хориглохоор тусгасан. Ингэснээр орон сууцанд оршин суугчдын эрүүл, аюулгүй, ая тухтай амьдрах нөхцөл сайжирна.

Мөн Эрхийн улсын бүртгэлд тусгах газрын хязгаарлагдмал эрх, гэрээгээр ашиглах эрх, үл хөдлөх эд хөрөнгийн үнийг тодорхойлох үндэслэл, дэс дарааллыг бодитой болгон зохицуулалтыг өөрчлөхөөр хуулийн төслийг боловсруулсан.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулж, ажлын зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд төрийн албан хаагчийг долоо хоногийн ажлын 1 өдөр зайнаас ажиллуулж болох зохицуулалтыг бий болгон замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, бусад улсын жишгээр ажлын бүтээмжийг нэмэгдүүлэхийг зорьсон.

Мөн Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн албан тушаалыг төрийн улс төрийн албан тушаалд хамааруулж, улс төрийн хариуцлага хүлээж байхаар тусгасан болно.

Нийслэл Улаанбаатар хотын аж ахуйд хамаарах төрийн үйлчилгээний албан тушаалыг төрийн захиргааны албан тушаалын ангилалд адилтган авч үзэх албан тушаалын жагсаалтыг Засгийн газрын саналыг үндэслэн төрийн албаны төв байгууллага батлахаар тусгасан нь нийслэл хотын аж ахуйн салбарт дутагдаж байгаа хүний нөөцийг бүрдүүлэхэд ач холбогдолтой юм.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5-т гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг чиглэлийг тодорхой заасан бөгөөд авто замын тэмдэг, тэмдэглэлийн талаар тусгаагүй. Зам тээврийн осол 2021 онд 22482, 2022 онд 24121, 2023 оны 8 дугаар сарын байдлаар 33.723 гарсан байна.

Иймд хуулийн дээрх заалтад авто замын тэмдэг, тэмдэглэлийг шинээр байршуулах, шинэчлэх, засварлах гэж нэмж оруулахаар төслийг боловсруулав.

Нийслэлийн Засаг дарга нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-т “Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, түүнчлэн тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн”, 59 дүгээр зүйлийн 59.1.10-т “гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг сахиулах чиглэлээр холбогдох хуулиар олгогдсон бүрэн эрхийг хэрэгжүүлэх”, 62 дугаар зүйлийн 62.1.9-т “гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг сахиулах чиглэлээр холбогдох хуулиар олгосон бүрэн эрхийг хэрэгжүүлэх” бүрэн эрхийг сум, дүүргийн Засаг дарга хэрэгжүүлэхээр заасан.

Иймд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг аймаг, сум, нийслэл, дүүрэгт Засаг даргаар удирдуулсан зөвлөл зохицуулах нь хуулийн хэрэгжилтэд нийцнэ гэж үзэж хуулийн төслийг боловсруулсан.

Сүүлийн 4 жилийн байдлаар гэмт хэрэг, зөрчлийг авч үзвэл 2020 онд 14.633 гэмт хэрэг, 1.753.050, 2021 онд 16.534 гэмт хэрэг, 1.602.613 зөрчил, 2022 онд 24.310 гэмт хэрэг, 2.075.830 зөрчил, 2023 оны 9 дүгээр сарын байдлаар 19.491 гэмт хэрэг, 1.695.052 зөрчил гарсан байна.

Хуульд өөрчлөлт орсноор гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын уялдаа холбоо, хариуцлага, хяналт сайжирна гэж үзэж байна.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Нийслэлийн айл өрхөд 2022 оны байдлаар бүртгэлтэй 48128 нохой, 2139 муур байна. Албан бус тоогоор 300-320 мянга гаруй эзэнгүй нохой, муур байна гэсэн тоо бий.

Нийт орон сууцанд амьдардаг 12 айлын нэг нь нохой, муур тэжээдэг. Харин гэр хорооллын айлын 30 гаруй хувь нь нохой, муур тэжээдэг гэх дүн мэдээ байна. Тэгвэл орон сууцанд амьдардаг иргэдийн 50 хувь нь нохойндоо вакцин хийлгэдэггүй бол, гэр хорооллын иргэдийн 77 хувь нь мөн л нохойндоо вакцин болон туулга хийлгэдэггүй байна. Нийслэлд 2021 онд 87442, 2022 онд 78,086, 2023 онд 65,667 эзэнгүй нохой, муурыг тус тус устгаж Цагаан давааны төвлөрсөн хогийн цэгт булшилсан. Нийслэлд гэрийн тэжээвэр амьтан, нийтийн байранд тэжээхийг хориглох амьтан, тэдгээрийн үүлдэр, асрамжлах газрын асуудлыг нарийвчлан

зохицуулсан дүрэм журам байдаггүйгээс иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөж байна.

Эзэнгүй муур, нохойг хүнлэг бус арга хэрэгслээр устгаж байгаа, түүнчлэн эзэнгүй муур, нохойг бүртгэх, түр байршуулах, устгахтай холбоотой зохицуулалтыг тодорхой болгох шаардлагатай байна.

Түүнчлэн нийслэлд амьтан худалдан борлуулдаг газар 6, амьтны хүрээлэн 2, амьтан түр байршуулах, худалдан борлуулах 4 газар үйл ажиллагаа явуулж байгаа хэлдий ч амьтан худалдан борлуулах, амьтны хүрээлэн ажиллуулах талаарх зохицуулалт тодорхойгүй байна.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 21/06 дугаар тогтоолоор мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрөх буюу хориглох бүсийн хил хязгаарыг шинэчлэн баталсан ч захиргааны хэм хэмжээний улсын нэгдсэн санд бүртгэгдээгүй байна. Иймд мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсийн хил хязгаарыг тогтоох, хориглосон бүсэд нэвтэрсэн малыг түр хадгалах, түүнтэй холбогдон гарсан зардлыг нөхөн төлүүлэх асуудлыг журамлах шаардлагатай байна.

Мал, амьтан хориглосон бүсэд нэвтэрсэн тохиолдолд авах арга хэмжээ болон оршуулгын үйл ажиллагаа, нийтийн эзэмшлийн гудамж, талбайн гэрэлтүүлэг, кабель, инженерийн бэлтгэл арга хэмжээний усны барилга байгууламжийн төлөвлөлт, ашиглалт, үйлчилгээтэй холбогдсон харилцааны эрх зүйн зохицуулалтыг бий болгохыг зорьсон.

Оршуулгын үйл ажиллагааг зохицуулсан хууль, журам байдаггүй учир энэхүү харилцааг зохицуулах зайлшгүй хэрэгцээ, шаардлага байгаа болно.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Зөвшөөрлийн тухай хуульд орон нутгийн, хот доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээвэр, такси үйлчилгээг тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэхээр заасантай холбогдуулан тусгай зөвшөөрөл олгоход хураах хураамжийг тусгаж, автотээврийн хэрэгсэлд техникийн үзлэг хийх тусгай зөвшөөрөл олгоход хураах хураамжийн хэмжээг өөрчлөхөөр тусгасан.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд замын хөдөлгөөний төлбөртэй бүсийн төлбөрийн талаар зохицуулалт тусгасантай холбогдуулан замын хөдөлгөөний төлбөртэй бүсийн төлбөрийг нийслэлийн төсвийн татварын орлогод хамааруулахаар тусгав.

Мөн Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулсантай холбогдуулан уг нэмэгдүүлсэн албан татварын орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлэхээр тусгасан.

Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Хот байгуулалтын тухай хуульд заасан цэцэрлэг, ногоон байгууламж, авто зогсоолын төлөвлөлт, барилгажилтад тавигдах шаардлага хангаагүй үл хөдлөх эд хөрөнгөд ногдуулах албан татварын хувь, хэмжээг 1 хүртэл хувиар нэмэгдүүлж тооцох эрхийг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд олгохоор тусгалаа.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл

Нийслэлийн хүн амын тал хувь нь гэр хороолол буюу инженерийн дэд бүтцийн хангамжгүй, агаар, хөрсний бохирдолтой нөхцөлд амьдарч байна.

Улаанбаатар хотын гэр хорооллын 163,742 яндан агаарын бохирдлын 31 хувийг үүсгэж байна.

Иймд орчны бохирдлыг бууруулах, төвлөрлийг сааруулах зорилгоор гэр хорооллыг орон сууцжуулах төсөл хэрэгжүүлэгчийн гэр хорооллыг орон сууцжуулах байршил болох дэд төвүүдэд нийтийн зориулалттай орон сууцны барилга байгууламж шинээр барихад шаардагдах барилгын материал, машин механизмыг импортлоход гаалийн албан татвараас 2028 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл чөлөөлөхөөр тусгасан.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Гэр хорооллыг орон сууцжуулах ажилд зориулан гэрээний дагуу гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх байгууллагад шилжүүлсэн газар эзэмших, ашиглах, өмчлөх эрх борлуулсны орлого болон нийслэлийн гаргасан өрийн бичиг /бонд/-ийн төлбөр, хүү, анзын орлогыг хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөхөөр тусгав.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх байгууллагад үйл ажиллагааны орлогод ногдох албан татварыг 90 хувиар, гэр хорооллыг орон сууцжуулах ажилд зориулан гэрээний үндсэнд гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх байгууллагад шилжүүлсэн газар эзэмших, ашиглах, өмчлөх эрх борлуулсны орлогыг чөлөөлөх байдлаар хуулийн төсөлд тусгаж 2028 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд дагаж мөрдөхөөр тусгалаа.

Мөн нийслэлээс гаргасан өрийн бичиг /бонд/-ийн төлбөр, хүү, анзийг Засгийн газрын бонд, Монгол Улсын Хөгжлийн банкны өрийн бичгийн нэгэн адил орлогын албан татвараас чөлөөлөхөөр тусгав.

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Хуулийн төсөлд нийслэлийн Засаг даргын газрын харилцааны талаар хэрэгжүүлэх бүрэн эрхийг тодруулж, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий болон тухайн жилийн төлөвлөгөөний дагуу газрын иргэнд өмчлүүлэх асуудлыг шийдвэрлэх, түүнчлэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших, ашиглах эрхийг хүчингүй болгох,

дуусгавар болгох, газрын байршил, хэмжээ, зориулалтыг өөрчлөх асуудлыг шийдвэрлэх эрхтэй байхаар тусгалаа.

Мөн нийслэл, дүүргийн газрын алба нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших эрхийг шилжүүлэх, газар эзэмших, ашиглах эрхийн хугацааг сунгах хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх эрх хэмжээ, чиг үүргийг тодорхой болгон газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг бий болгохоор тусгасан.

Мөн газар өмчлүүлэх, газар эзэмших, ашиглах, чөлөөлөхтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий орон тооны бус нийслэлийн газрын эрхийн маргаан таслах зөвлөлийг ажиллуулахаар хуулийн төслийг боловсруулсан. Үүнтэй холбогдуулан нийслэлийн нутаг дэвсгэр дэх газартай холбоотой маргаан шийдвэрлэх зохицуулалтыг тусгайлан зохицуулахаар тусгасан.

Хуулийн төслөөр нийтийн эдэлбэрийн газар, нийслэл хотын эдийн засгийн тусгай бүсийн газрын зориулалтаар улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээнд авч, эдийн засгийн тусгай бүсийг хөгжүүлэх, нийтийн эдэлбэрийн газрын хүртээмжийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлсэн.

Эрх бүхий байгууллагаас олгосон газар өмчлөх, эзэмших, ашиглах газрын эрхээ хэрэгжүүлэх, хүн амын нийтийн ашиг сонирхлыг хангах зайлшгүй шаардлагатай тохиолдолд бусдын өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг хязгаарлаж сервитут тогтоох эрх зүйн үндсийг бий болгосон.

Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Барилга байгууламж ашиглалтад оруулах комиссын ажиллах зардлын хэмжээг барилга байгууламжийн төвөгшил, хэмжээг харгалзан тогтоохоор тусгав.

Дээр дурдсан хуулиудыг зөрчсөн тохиолдолд холбогдох зөрчилд ногдуулах шийтгэлийг Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд, шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтныг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд тус тус тусгав.

Авто замын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Авто зогсоолын төлбөрийн дээд, доод хэмжээг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоох ба энэ хязгаарт багтаан авто зогсоолын үйлчилгээ эрхлэгч авто зогсоолын төлбөрийн хэмжээг тогтоох зохицуулалтыг тусгалаа.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Богдхан уулын дархан цаазат газрын хилийн заагийн хэмжээг бууруулахгүйгээр хилийн цэст өөрчлөлт оруулах асуудлыг судалж, холбогдох саналаа шийдвэрлүүлэх болон улсын хэмжээнд нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар албадан чөлөөлөхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг бий болгох хуулийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгахаар тогтоолын төсөлд тусгасан болно.

---o0o---